

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 30-НЫ ӨДРИЙН ЭЭЛЖИТ ШУУРХАЙ
ЗӨВЛӨГӨӨНӨӨР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР**

2025 оны 12 дугаар сарын 30

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
1	Үүрэг, даалгавар НЭГ: Нийслэл Улаанбаатар хот 2026 оныг Бизнес эрхлэгчдийг дэмжих жил болгон зарласан талаар олон нийтэд танилцуулах ажлыг зохион байгуулах. Нийслэл 2026 оныг “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан 2026 онд бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, төвлөлөгөөг боловсруулах, бэлтгэл ажлыг үе шаттайгаар зохион байгуулах төвлөлөгөөг хэлэлцэхээр дүүргийн Засаг даргын дэргэдэх зөвлөлийн ээлжит хурал товлож, бэлтгэл ажлыг хангаад байна. Мөн Нийслэлээс гаргасан уг шийдвэрийн талаарх мэдээллийг дүүргийн албан ёсны цахим хуудас болон олон нийтийн сүлжээгээр тогтмол түгээн ажиллаж байна.			90%
2	Үүрэг, даалгавар ХОЁР: Дүүргүүдийн бүтэц, орон тоонд чиг үүргийн шинжилгээ хийж, үйл ажиллагааны давхардлыг арилгах, төсвийн зардлыг хэмнэсэн бүтцийн өөрчлөлтийн санал боловсруулж, танилцуулах.			
2	Дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн А/105 дугаар тушаалаар ажлын байрны шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, Тамгын газрын нийт 10 хэлтэс, нэгжийн албан хаагчдын албан тушаалын чиг үүрэг, ажлын ачаалал, хийдэл болон давхардлыг тодорхойлох ажлын байрны шинжилгээг хийсэн. Ажлын байрны шинжилгээг хэлтэс тус бүрийн албан хаагчидтай ярилцлага хийх, асуумж авах, албан тушаалын тодорхойлолт болон холбогдох баримт бичигт тулгуурлан гүйцэтгэсэн тухай албан бичгийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03/3718 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.			100%

<p>Үүрэг, даалгавар ГУРАВ: Нийслэлийн гэр хорооллын газрыг чөлөөлж, дэд бүтэц суурилуулсан газарт барилгын бизнес эрхлэгчид орон сууц барьж, газрын телберт тухайн барилгын тодорхой хэсгийг нийслэлийн ипотекийн зээлээр худалдан борлуулах боломжийг бүрдүүлэн, дэмжлэг үзүүлэх виртуал танилцуулга бэлтгэн танилцуулах.</p>			
3	<p>Нийслэлийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/1392 дугаар захирамжаар дүүргийн гэр хороолол дунд байрших 9 дүгээр хорооны ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалтай орон сууцны 65, 66, 67, 68, 69, 181 дугаар байрны барилгыг буулган дахин барилгажуулах ажлыг “Улаанбаатар орон сууцжуулалт” ХХК-д шилжүүлэн иргэдтэй зөвшилцөх, барилгын зураг төсөл боловсруулах шатандаа хэрэгжиж байна.</p>		100%
<p>Үүрэг, даалгавар ДӨРӨВ: Шинэ жилийн баярын өдрүүдэд эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлж ажиллах.</p>			
4	<p>Дүүргийн нутаг дэвсгэрт гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг, удаа дараа давтамжтай дуудлага мэдээлэл ирүүлдэг аж ахуй нэгж байгууллагын судалгааг гаргаж дуудлага мэдээллийг бууруулах чиглэлээр 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөс “Эмзэг цэг” хэсэгчилсэн арга хэмжээг 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт зохион байгуулан ажилласан. Арга хэмжээний хүрээнд авто эргүүлийн 12 чиглэлд 24 алба хаагч 24 цагаар, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын даргын Б/278 дугаар тушаал, “Эргүүл ажиллуулах тухай” тушаалын хэрэгжилтийг хангах чиглэлээр явган эргүүлд өдөр бүр 23:00-05:00 цагийн хооронд 5 чиглэлд 10 алба хаагч, давхардсан тоогоор 60 алба хаагч 24400 хүн/цагийн үүрэг гүйцэтгэн ажилласан.</p> <p>Мөн Шинэ жилийн баярын өдрүүдэд эмх замбараагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, архигүй шинэ жил арга хэмжээ, давтамжтай дуудлага мэдээллийг бууруулах чиглэлээр 625 аж ахуй нэгж байгууллага шалгаж 730 аж ахуй нэгжид тус хэлтсийн 202503019622, 202503020069, 202503019772 дугаартай зөвлөмж өгч давхардсан тоогоор 5610 иргэнд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийсэн. Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй, давтамжтай дуудлага мэдээлэл ирүүлдэг 19 айл өрхөд давхардсан тоогоор 475 удаа авто эргүүлийн алба хаагчид дуудлага мэдээлэлгүй үедээ хяналт тавьж яриа таниулга хийж ажиллаж байна.</p> <p>Мөн дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Нарлаг дэнж” ХХК, “Хүчит шонхор” ХХК, “Нарантуул-2” зах худалдааны төвийн удирдлага, харуул хамгаалалтын хариуцсан албан тушаалтан нартаа уулзаж, баяр амралтын өдрүүдийг тохиолдуулан үйлчлүүлж байгаа иргэдийн аюулгүй байдлыг хангах, халаасны хулгайн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Лед дэлгэц, байгууллагын дотоод чанга яригч дээр өдөр бүр гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх яриа таниулга явуулж ажилласан</p>		100%

<p>Үүрэг, даалгавар ТАВ: Шинэ жилийн баярын өдрүүдэд хариуцлагатай жижүүр томилон ажиллуулж, болзошгүй эрсдэлт байдал үүссэн тохиолдолд удирдлагад яаралтай танилцуулан, шуурхай арга хэмжээ авч, үр дүнг тайлагнах.</p>	
5	<p>Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/200 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын Б/456 дугаар тушаалыг дүүргийн 1-ээс 24 дүгээр хороодод хүргүүлэн, хариуцлагатай жижүүрээр ажиллах албан хаагчдын хуваарийг гаргасан. 2025 оны 12 дугаар сарын 30-ны өдрөөс 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хариуцлагатай жижүүрээр ажилласан тайлан мэдээг Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв ОНӨТҮГ-ын программ хангамжийн инженерт хүргүүлэн ажилласан.</p>
<p>Үүрэг, даалгавар ЗУРГАА: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагч бүрт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тухай сургалт явуулах.</p>	
6	<p>Төрийн бүх шатанд байгаа авлигыг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор холбогдох байгууллага, "Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх соён гэгээрүүлэх хэлтэс"-тэй хамтран сургалтыг албан хаагч нарт танхим болон цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулах төлөвлөгөөг гарган ажиллаж байна.</p>
<p>Дундаж үнэлгээ:</p>	
<p>90%</p>	

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ж.ТАМИР

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Г.ОТГОНТӨГС

НЭГТГЭЖ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.ДОЛГОРМАА